

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, шаардлагад нийцсэн байна.

1. Нийлүүлэгч нь хамгийн санал болгосон үнээр 4 улирлын нөхцөлд тохирсон / АИ-92, дизель түлш / худалдан авагч талд **4 улирлын турш** бэлэн бус хэлбэрээр /талон/ олгох.
2. Нийлүүлэх авто шатахуун нь **ОХУ-ын ГОСТ Р 51105-97** стандартын дагуу үйлдвэрлэгдсэн болон түүнтэй дүйцэхүйц чанар стандартыг хангасан байна. Өөр гарал үүсэлтэй бараа нийлүүлэх тохиолдолд тухайн барааг үйлдвэрлэсэн стандарт нь **Монгол улсын MNS 0217:2006** стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ. Нийлүүлэх хөдөлгүүрийн тос нь **Монгол улсын MNS 3995:2010** стандартыг хангаж байгааг нотолсон бичиг заавал ирүүлнэ.
3. Нийлүүлэгдэх бараа “**АИ-92, ДТ**” хөдөлгүүрийн тос нь үйлдвэрийн болон бусад шалгалт, туршилтын жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт ирүүлнэ. Холбогдох стандартад нийцэж байгааг болон түүнээс илүүгээр хангаж байгааг харуулсан дагалдах бичгүүдийг заавал хавсаргана.
4. Шатахуун, хөдөлгүүрийн тосыг 2024 оны 3-12 сарын туршид тасралтгүй хангах бөгөөд зах зээл дээр шатахуун, хөдөлгүүрийн тосны хомсдол гарсан нөхцөлд гэрээт байгууллагын үйл ажиллагааг зохих түвшинд хангах шатахуун, хөдөлгүүрийн тосны нөөцтэй байх..
5. Төв аймгийн 27 суманд заавал салбартай байх. /**ШТС –уудын хаяг, байршилыг харуулсан газрын зураг хавсаргах**/
6. Нийлүүлэх барааны нэгж үнийн санал ирүүлнэ.
7. Нийлүүлэгч тал нь сар бүр ШТС –д түгээж байгаа шатахуун, тосны дээжийг итгэмжлэгдсэн лаборатороор шинжлүүлж дүнг гаргуулсан байх. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь итгэмжлэгдсэн шинжээчийг дуудаж дээж авч тухайн шатахууны сорилыг тодорхойлно.